




**ХУУРАМЧ ИМЭЙЛ-ИЙГ  
ХЭРХЭН ТАНЬЖ МЭДЭХ ВЭ ?**

## Хуурамч имэйл таньж мэдэх

Мэдээлэл технологийн эрин үед имэйл хаягаар дамжуулан хэрэглэгчийн хууль ёсны мэдээллийг олж авах оролдлого ихээхэн гарсаар байна. Хэрэглэгчийн интернет нууц үг , мэдээллийг авахын тулд хуурамч имэйл илгээх , веб хуудас дуурайлган хийх гэх мэт өгөөш имэйл явуулдаг байна. Халдагч тал хуулбар имэйл үүсгэх халдлага нь таны өмнө нь харилцаж байсан имэйл-ээс контент болон хүлээн авагчийн имэйл гэх зэрэг мэдээллийг олж авснаар энэхүү халдлага хийгддэг. Яг ижил имэйлээс илгээхдээ хортой код линк хавсаргаж өгдөг. Ихэвчлэн өөрийн хаягаа далдлаж яг ижилхэн имэйлээс ирсэн мэт харагдуулдаг байна. Халдагчийн имэйлүүд ихэвчлэн тухайн халдаж буй хэрэглэгчтэй хамааралтай вебсайт , харилцаж байдаг албан байгууллагаас явуулсан юм шиг харагддаг учир хүлээн авсан хүн сэжиглэх нь бага байдаг байна. Имэйлүүд дараах утга агуулга ихэвчлэн агуулсан байдаг байна.

- Дансны дугаар өөрчлөгдсөн тул ийшээ мөнгө шилжүүлнэ үү
- Захирлынх нь өмнөөс , эсвэл харилцагч байгууллагын өмнөөс имэйл илгээн өөр данс руу мөнгө шилжүүлэх
- Аюулгүй байдлаа хангахын тулд дараах зааврын дагуу тохиргоо хийнэ үү хэмээн нууц үг олж авах
- Таны имэйлын багтаамж дүүрсэн тул та нууц үгээ шинэчлэнэ үү . Линк хавсаргасан файлтай хамт илгээнэ
- Дараах мэдээллийг бөглөж өгнө үү хэмээн файл илгээдэг
- Эсвэл attachment файл хавсаргасан байдаг байна гэх мэт таниас мэдээлэл цуглуулах, таныг хохироох боломжтой бүхий л имэйлийг илгээдэг байна.

### Жишээ нь :




Зураг . Хуурамч имэйл илгээсэн байдал

Яагаад энэхүү халдлага хийх боломжтой байгаад байна вэ гэвэл тухайн хэрэглэгч нь өөрийн компьютер дээр ямар имэйл сервер дамжин орж ашиглаж байгаа болон ашиглаж буй хэрэглээний програмаас (Outlook , Thunderbird , гар утасны апп гэх мэт ) ихээхэн шалтгаалж байгаа юм. . Жишээ нь та лицензгүй Outlook болон лицензгүй windows үйлдлийн систем ашигладаг байлаа гэж бодоход таны имэйлийн бүхий л дата нууц үг таны өөрийн компьютер дээр хадгалагдаж байдаг. Таны имэйлын дата outlook.pst (C:\Documents and Settings\ \Local Settings\Application Data\Microsoft\Outlook\ ) файл дотор хадгалагдаж байдаг. Эсвэл хэт амархан нууц үг хийснээс болж түлхүүр таамаглах аргыг ашиглан түлхүүр үгнүүдээр хайлт хийж халдагч өөрийн серверт олдсон датаг цуглуулж таны өмнөөс харилцаж байсан хүнтэй өмнөөс чинь харилцаж луйвар хийдэг байна.



### Зөвлөмжүүд :

- Та лизенцтэй үйлдлийн систем (windows ) болон лизенцтэй хэрэглээний програм ашиглаарай.
- Имэйл шифрлэн илгээдэг нэмэлт програмуудыг ашиглах хэрэгтэй
- Ирсэн имэйлийн мэдээллийг нягтлан сайн харах (жишээ нь : administrator@outlook.com гэсэн хэрэглэгчтэй байнга та харилцдаг байтал таньд нэг өдөр adminestrator@outlook.com гэсэн хаягнаас имэйл ирэх жишээтэй. )
- Мөн хамгийн энгийн хуурамч имэйл ирснийг мэдэх арга нь email header тулгаж хуурамч имэйл эсэхийг мэдэх боломжтой . Show original дээр дарж имэйд header харах боломжтой.



Зураг . Интернет header харах

Имэйл header дээр бүхий л мэдээлэл агуулагдсан байдаг . From хэсгийг имэйд илгээж буй ихэвчлэн сольсон байдаг. Таны шалгах хэрэгтэй хамгийн чухал зүйл нь ямар хаяг руу буцаж имэйл явж байгааг (return-path). Харин хэрэглээний програм болох outlook дээр email header-ыг харахдаа имэйлээ 2 удаа товшиж дээр байрлах талбаруудаас option хэсгийг дарж Message options хэсгээс email header-ыг хардаг.

- Мөн outlook дээр тохиргоо хийхдээ us2.pop.mailhostbox.com болон us2.smtp.mailhostbox.com гэсэн тохиргоог хийж өгөх хэрэгтэй . Мөн 587 портыг ашиглах хэрэгтэй ба ssl эсвэл tls идэвхижүүлсэн байх шаардалагатайг анхаарна уу .

**Add Account**

**POP and IMAP Account Settings**  
Enter the mail server settings for your account.

**User Information**

Your Name: Administrator  
Email Address: administrator@test.mn

**Server Information**

Account Type: POP3  
Incoming mail server: us2.pop.mailhostbox.com  
Outgoing mail server (SMTP): us2.smtp.mailhostbox.com

**Logon Information**

User Name: administrator@test.mn  
Password: \*\*\*\*\*  
 Remember password  
 Require logon using Secure Password Authentication (SPA)

**Test Account Settings**

We recommend that you test your account to ensure that the entries are correct.

Test Account Settings ...  
 Automatically test account settings when Next is clicked

**Deliver new messages to:**

New Outlook Data File  
 Existing Outlook Data File  
Browse

More Settings ...

< Back   Next >   Cancel

Зураг . POP болон smtp сервер тохируулах

**Internet E-mail Settings**

General   **Outgoing Server**   Advanced

**Server Port Numbers**

Incoming server (POP3): 110   Use Defaults  
 This server requires an encrypted connection (SSL)

Outgoing server (SMTP): 587  
Use the following type of encrypted connection: SSL

**Server Timeouts**

Short   Long 1 minute

**Delivery**

Leave a copy of messages on the server  
 Remove from server after 14 days  
 Remove from server when deleted from 'Deleted Items'

OK   Cancel

Зураг . smtp порт тохируулах (587 порт байх ёстой)